

Газрын даргын 2024 оны дугаар
сарын -ны өдрийн дугаар
тушаалын хавсралт



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БУУЛГАХ АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/.....
Холбоо барих утасны дугаар :
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр :
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

Тайлбар:

- Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/961 дүгээр захирамж
- Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-т заасан зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж заасны дагуу холбогдох материалуудыг скайнердаж PDF өргөтгөлтэйгөөр цаасан болон цахим хэлбэрээр BAZG@uda.ub.gov.mn хаягаар ирүүлнэ үү. PDF өргөтгөлтэй файлын хэмжээ 5MB-ээс доош байна.
- Материалын бүрдлийг PDF өргөтгөлтэй цахим хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгогдохгүй болохыг анхаарна уу.

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙГ БУУЛГАХ АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

№	Үндэслэл, хуулийн заалт	Баримт бичгийн жагсаалт, тайлбар	Бүрдэл
1.	Барилгын тухай хууль 28.2, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Захиалагчийн өргөдөл, албан бичиг, иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрчилгээ, кадастрын хуулбар Жич: <i>Хүсэлтийг зөвхөн захиалагчаас ирүүлэх.</i>	
2.	Барилга байгууламжийг буулгах шийдвэр	Барилгыг буулгах шийдвэр /Жич: <i>Зөвхөн төрийн өмчийн барилгад шаардана./</i> Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ	

3.	<p>Барилгын тухай хууль 8.2, 8.3, 8.4, 28.2.5.</p> <p>Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.</p>	<p>Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч нь тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулж гэрчилгээг хавсаргах.</p> <p><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i></p>	
4.	<p>Барилгын тухай хууль 28.3.</p> <p>Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.</p>	<p>Барилгын буулгалтын ажлын ерөнхий гүйцэтгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар.</p> <p><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i></p>	
5.	<p>Барилгын тухай хууль 16.3.</p> <p>“Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12</p> <p>Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.</p>	<p>Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг төслийг барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр баталгаажуулж ирүүлэх.</p>	
6.	<p>Барилгын тухай хууль 28.4, 30.1</p> <p>Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана.</p> <p>Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.</p>	<p>Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх календарчилсан график төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлэх.</p> <p><i>Жич: Барилгын ажлын зөвшөөрлийг календарчилсан график төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно.</i></p>	
7.	<p>“Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12</p> <p>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал</p> <p>Барилгын хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөлтэй этгээд /тээвэрлэгч/ холбогдох хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг барилгын хог хаягдлыг үүсгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулж тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.</p>	<p>Захиалагч нь барилгын хог хаягдал тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй /тээвэрлэгч/ байгуулсан холбогдох хууль тогтоомжид нийцсэн хог хаягдал тээвэрлэлтийн гэрээг ирүүлэх.</p> <p><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i></p>	

8.	Барилгын гэрэл зураг /фото/	Буулгах барилгын гэрэл зураг /фото/ хавсаргах	
----	-----------------------------	--	--

Зөвлөмж:

1. Зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд нь Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ гарсны дараа **Тэмдэгтийн хураамж 20.000₮-ийг Төрийн сан 100200051054** дугаар дансанд тушаана уу. **Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй нэгж бол байгууллагын регистрийн дугаар, цахим хаяг бичих.**
2. Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ “Барилга үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-04-06, “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД20-101-12-ийг мөрдлөг болгон барилгын ажлын талбайн орчны хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулж, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хүсэлт хүлээн авсан ажилтан/...../

нэр

..... оны..... сарын.....өдөр